

Дотоод аудит хийгдэх нэгж : ЭДЦС” ТӨХК - СЭЗХ

**“ЭДЦС”ТӨХК-ийн IV дугаар улирлын санхүүгийн тайланд  
хийгдсэн дотоод аудитийн ажлын тайлан**

Эрдэнэт хот

АУДИТЫН ТӨРӨЛ: Нийцлийн аудит

АУДИТЫН ХИЙХ ХУГАЦАА: 2022-02-10 -ээс 03-р сарын 10-нийг дуустал ажлын 21 өдөр

### ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

**1. Аудит хийх үндэслэл:** Дотоод аудиторын жилийн ажлын төлөвлөөгөөний дагуу гүйцэтгэх захирлаар батлуулсан хөтөлбөрийн хүрээнд хийнэ.

### 2. АУДИТЫН ЗОРИЛГО

“ЭДЦС”ТӨХК-ийн жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт хийж, зөвлөмж боловсруулан холбоглох албан тушаалтанд танилцуулах, хэрэгжүүлэхэд оршино.

### 3. ХАМРАХ ХҮРЭЭ:

“ЭДЦС” ТӨХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, авлага өглөгийн журнал, анхан шатны баримтууд, ажилчдын цалин хөлсний тооцоолол болон бусад холбогдох баримт бичгүүдийг хамруулав.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ: Үүнд

- Санхүүгийн тайланд хийх аудит
- Өр авлагын харьцаа, барагдуулсан байдал
- Цалин, бараа материал, харилцах, кассын анхан шатны баримт
- НДШ, ХХОАТ-ын тайлагналт
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт,

### 4. Аудитын арга зүй, стандартын мэдэгдэл:

Холбогдох ажилтантай ярилцах, тайлбар тодруулга авах, санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх, анхан шатны баримт материалыг шалгах, тулган баталгаажуулах зэрэг арга зүй ашиглан цуглуулсан нотлох баримт судалгаанд баримтад дүн шинжилгээ хийж, нэгтгэн аудитын дүнг боловсруулж, түүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж өглөө.

Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт явуулах зохион байгуулах нийтлэг журам, ЭДЦС” ТӨХК-ийн дотоод хяналт шалгалт хийх журмын дагуу аудитын дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс , ажлын баримтыг хавсаргав.

### 5. Аудитын шалгуур үзүүлэлтийн харьцаа

Аудит хийхэд дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.Үүнд

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
- “ЭДЦС” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- ХХОАТ-ын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж

## Танилцуулга:

2021 оны тайлант хугацааны эцэст нийт 84,550.2 сая төгрөгийн хөрөнгөтэй, Үүнээс 9,453.2 сая төгрөгийн эргэлтийн, 84,550.2 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй байна. , Мөнгөн гүйлгээ тайлан нийт 45,372.0 сая төгрөгийн мөнгөн орлого орж, 30,479.9 сая төгрөгийн мөнгөн зарлага гарч, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 422,6 сая төгрөг байна

Харилцах: Оны эхэнд харилцах дансны үлдэгдэл 1,054.8 сая төгрөг байсан. Харилцах дансанд бүгд 51,644.1 сая төгрөг орлого орж, 52,395.1 сая төгрөг зарлага гарч , тайлангийн эцсийн үлдэгдэл 303.8 сая төгрөг байна.

Касс: Эхний үлдэгдэл 4.6 сая төгрөг байсан. Тайлант хугацаанд 13.4 сая төгрөг төвлөрүүлж, 12.3 сая төгрөг зарцуулж, тайлангийн эцсийн үлдэгдэл 5.7 сая төгрөг байна.

Авлага тайлангийн эцэст 5,709.1 сая төгрөг болж оны эхнээс 2,124.7 сая төгрөгөөр буурсан.

**ЦЭХ-ний авлага:** Нийт авлагын 94.9%-ийг эзэлж байна. Оны эхэнд 3,157.8 сая төгрөг байсан ба тус хугацаанд 41,692.1 сая төгрөгийн /НӨАТ-тай/ ЦЭХ ДҮТ ХХК-д худалдсан. Бүгд оны эхний үлдэгдэлтэй нийт 44,849.9 сая төгрөгийн санхүүжилт хийхээс 39,432.4 сая төгрөгийн санхүүжилт хийж, 5,417.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь оны эхнээс 2,259.7 сая төгрөгөөр нэмэгдсэн.

**ДЭХ-ний авлага:** Өнгөрсөн оны мөн үед 147 байгууллагаас 412.5 сая төгрөгийн авлагатай гарсан бол тайлант хугацаанд 53 байгууллагаас 288.0 сая төгрөгийн авлагатай гарч авлага 124.4 сая төгрөгөөр буурсан. 2021 оны эхэнд Засгийн газрын ДЭХ-ний авлага 192.8 сая төгрөг байсан тайлант хугацаанд 1,395.6 сая төгрөгийн авлага үүсч, 1,409.5 сая төгрөгийн авлага барагдуулж тайлант хугацааны эцэст 178.9 сая төгрөгийн авлагатай гарав.

**Хувь хүмүүсийн авлага:** Ажилчид, хувь хүний тооцоо. Хувь хүнээс авах авлага оны эхэнд

**Дансны авлага:** Бэлтгэн нийлүүлэгч болон системийн байгууллагын авлага.

**Бараа материалын үлдэгдэл** 2021 онд 20,568.4 сая төгрөгийн түлш, түүхий эд, сэлбэг, бараа материалыг орлогод авч, 21,443.8 сая төгрөгийн түлш, түүхий эд, сэлбэг, бараа материалыг зарлагадан нийт агуулахын үлдэгдэл нь 2,402.2 сая төгрөг болж оны эхний үлдэгдлээс 875.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хувь хүнээс авах авлага оны эхнээс 2.7 сая төгрөгөөр өссөн байна

Оны эхэнд эздийн өмч 87,211.2 сая төгрөг байсан ба тайлант хугацаанд 84.1 сая төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлж, алдагдал 3,010.3 сая төгрөгөөр буурч 84.1 сая төгрөг үзүүлэлттэй тайлан гаргаж хуулийн хугацаанд холбогдох газруудад хүргүүлсэн байна.

## 6. АУДИТЫН ҮР ДҮН

### 6.1.0. Илэрсэн зөрчил

1. 2021 оны 09-р сарын 29 өдөр шилХарилцах дансаар шилжсэн компаниудын нийт ,,,, төгрөгийн тооцоог илүү бодож шилжүүлсэн авлага үүсгээгүй байна.
2. Цалин хөлсний эдийн засагч ээлжийн амралттай ажилчдын цагийн балансыг хянаж илүү олгосон цалинг буцааж суутгах ХААХ Гантөмөр – 18 хоног, цахилгаан цех Доржзодов 5 хоног /
3. Хөдөлмөрийн чадвараа түр алдсан буюу өвчилсөн дараах ажилтнуудад илүү хоногийн цалин оруулсан / ДШС /Тунгалаг -10 хоног, цахилгаан цех Доржзодов 5 хоног Турбин цех Цогоо 1 хоног /

4. Нийгмийн даатгалын шимтэглийн дансны үлдэгдэл үлдэгдэл сүүлийн 3 сар зөрсөн, 10 дугаар сард ,,.,.,., төгрөгөөр 11 дүгээр сард ,,.,., төгрөгөөр, 12 дугаар сард ,,.,., төгрөгөөр тус тус зөрсөн байна. Алдааг залруулж зөрүүг олох
5. Ажилчин албан хаагчдаас авах авлага оны эхэнд ,,.,., төгрөгбайсан ба оны эцэст ,,.,., төгрөг болсон байна. Өмнө байсан авлагууд барагдуулаагүй барагдуулах ажил хийгдээгүй шинээр үүссэн өрүүдийг барагдуулах ажил зохион байгуулаагүй байна.

#### **Дүгнэлт.**

Санхүүгийн нөхцөл байдлыг тодорхойлдог дээрх харьцаануудаас харахад үнэ тарифыг өмнөх оноос бууруулан баталснаар өмнөх онтой харьцуулахад санхүүгийн харьцаанууд бүгд буурч гарсан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байсан, Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу авлага 3 дугаар улирлын дуустал сайн цугларсан, худалдан авалт, Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт, урсгал зардлын төлөвлөгөөг оновчтой хийж, мөнгөн урсгалыг төлөвлөж ажилласнаар бусдад төлөх төлбөрийг барагдуулан санхүүгийн хямралд ороогүй ажилласан.

Сүүлийн улиралд төрөөс даасан эрчим хүчний төлбөр хугацаандаа орж ирээгүйгээс авлага өр төлбөр нэмэгдэж гарав.

Үнэ тарифыг жил шинэчлэн тооцдоггүй, 2-3 жилийн өмнөх БОШХ-ээр тооцон баталдаг, тухайн жилд хийгдэх хөрөнгө оруулалтын элэгдлийг тооцохгүй байх нь мөнгөн хөрөнгийн дутагдалд орох, шаардлагатай, чанартай их засвар хийх, шинэ орчин үеийн техник технологи авах, ажилчдад хангалттай цалин хөлс олгох, нийгмийн байдлыг хангах, сургах, тогтвор суурьшилтай ажиллахад сөргөөр нөлөөлж байна.

**Дүгнэлт:** Санхүүгийн үйл ажилгааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хөтөлж, тайлан балансыг хугацаандаа гаргаж хэвшсэн, татвар нийгмийн даатгалд өргүй, ноцтой зөрчилгүй хэвийн ажиллаж байна гэж дүгнэлээ.

Дараа тайлангууд тайлант хугацаанд журмын дагуу хаагдсан байна.

Шилэн дансны мэдээллийг журмын дагуу, хуулийн хугацаанд нь оруулсан байна

#### **Зөвлөмж:**

1. Анхан шатны баримтуудыг Сангийн сайдын баталсан НХ-маягтуудаар хөтлөн явуулсан байна Гэвч зарим нэг баримтын дэмжих анхан шатны баримтыг бүрдүүлэх/
2. Хөдөлмөр цалин эдийн засагч ээлжийн амралттай ажилчдын цагийн балансыг дахин хянаж, зөрчлийг арилгах
3. Хөдөлмөр цалин хөлсний эдийн засагч өвчилсөн ажилчдын цагийн балансыг дахин хянаж, зөрчлийг арилгах
4. Нэр дурдсан ажилчдаас илүү олгосон цалинг буцааж суутгах
5. Зам,тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390-р тушаалын хавсралтаар баталсан автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг мөрдлөг болгон "ЭДЦС" ТӨХК-ийн 2018 оны 03 сарын 27 өдрийн А/40 тушаалаар баталсан "Автомашины шатахуун, сэлбэгийн норм, тооцоо бодох журам"-ыг яаралтай шинэчилж, мөрдөх шаардлагатай. Өмнөх улиралд өгсөн зөвлөмж биелээгүй.

6. 35613 табельтай ТДЦ-д ажилладаг байсан У.Баяраа дээр үүссэн өрийг энэ ондоо багтаан залруулж, ажилтан албан хаагчдаас авах өр авлагыг бууруулах

Танилцсан: ДХХ-ийн дарга

М.Галхүү

Тайлан бичсэн: Дотоод аудитор

О.Оюунжаргал